

## МОНГОЛ - ТУРКИЙН ХАРИЛЦААНЫ ШИНЭ ҮЕ

*Б.Мандхай\**

XX зууны сүүлийн хагаст Монголчууд тусгаар тогтнолоо олсны дараагаар дэлхийн олон улс орнуудтай дипломат харилцаа тогтоож ирсэн билээ. Үүний нэг нь Турк улс бөгөөд Бүгд найрамдах Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд 1969 оны 10 сарын 24-ний өдөр албан ёсоор дипломат харилцаа тогтоосон. Манай улстай дипломат харилцаа тогтоосон 41 дэх улс болсон юм. Гэвч тухайн үед дэлхий ертөнцөд ноёрхож байсан “хүйтэн дайн”-ны нөлөөгөөр эсрэг бусад улсуудын нэгэн адил тэр бүр хөгжилгүй зогсонги байдалтай байсаар ирсэн юм.

Тиймдээ ч өрнийн улс орнуудын нэгэн адил ерөнхий гурван үе шат болгон хуваан авч үзэж болно. Үүнд 1. Эртний харилцаа буюу эрт цагаас 1969 он хүртэл, 2. “Хүйтэн дайн” үзэл сурталт нийгмийн үе (1969-1990 он) 3. Шинэ үеийн харилцаа буюу (1990 оноос өнөөг хүртлэх үе) гэж үзэж болох юм.

Эрт үеийн харилцааны түүх харьцангуйгаар нилээд нарийн судлагдсан. Харин сүүлийн үед шинэ үеийн харилцааны түүхийг сонирхон судласан судлаачид цөөнгүй ном бүтээл гаргаж байна. Энэ удаад миний бие шинэ үеийн харилцааны талаарх өөрийн судалгааг танилцуулж байна.

1990 оны ардчиллаас хойших хугацаанд хоёр улсын хоорондын хамтын ажиллагаа, төр, засгийн өндөр дээд хэмжээний айлчлал олноор хийгдэн, 1995 оноос шинэ шатанд гарч Монгол Улсын Ерөнхийлөгч 1998, 2004 онд, УИХ-ын дарга 1993, 2002 онд, Ерөнхий сайд, 2006 онд, Гадаад харилцааны сайд 1992 онд Туркт, БНТУ-ын Ерөнхийлөгч 1995, 2002 онд, УИХ-ын орлогч дарга 1994 онд, Ерөнхий сайд 2005 онд Монголд Улсад тус тус харилцан айлчилж, Монгол, Туркийн харилцааны эрх зүйн үндэс болсон олон чухал баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан болно.

1993 онд Туркийн Засгийн газрын эдийн засгийн төлөөлөгчид Монголд айлчилж, манай холбогдох яам, газрын удирдах хүмүүстэй уулзаж хамтын ажиллагаа хөгжүүлэх асуудлаар санал солилцон “Жижиг, дунд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх тухай протокол” байгуулав. Мөн геологи, эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах талаар хоёр тал санал солилцсон байна.

1994-1995 онд “МҮАҮТ, ТИКА-гийн хооронд хамтран ажиллах тухай меморандум”, “Монгол Улсын ЭХГУУЯ, БНТУ-ын Эрчим хүч,

\* Б.Мандхай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

байгалийн нөөцийн яамны хоорондын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”, “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”-г тус тус гарын үсэг зуржээ. 2001 оны 7-р сарын сүүлээр БНТУ-ын Төрийн сайд, Монгол, Туркийн эдийн засаг, худалдааны хамтарсан хорооны Туркийн хэсгийн дарга А.М.Чай тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчилсан. Айлчлалын үеэр “Монгол-Туркийн эдийн засаг, нийгмийн салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын харилцан ойлголцох санамж бичиг” болон “МУИС, ТИКА-гийн хооронд Түрэг судлалыг дэмжих хамтын ажиллагааны Хөтөлбөр”-г тус тус гарын үсэг зурсан юм.

Монгол, Туркийн Засгийн газар хоорондын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хороо 1994 онд байгуулагдаж, хамтарсан хорооны анхдугаар хуралдаан 1995 онд Анкарад, II хуралдаан 1998 онд Улаанбаатарт болж, цаашид хамтран ажиллах чиглэлээр протокол байгуулсан.

Тус хорооны III хуралдааныг 2001 оны 9-р сарын 24-25-ны өдрүүдэд Анкара хотноо зохион явуулсан юм.

Монгол-Туркийн Бизнесийн Зөвлөл 1999 онд байгуулагдсан нь хоёр орны ажил хэрэгч хүмүүсийг холбох, хөрөнгө оруулалтыг Монголд оруулах зэрэгт дэмжлэг үзүүлж байна. Монгол-Туркийн Бизнесийн Зөвлөлийн Анхдугаар хуралдаан мөн 2001 оны 9-сарын 21-ны өдөр Стамбул хотноо хуралдав.

2002 оны 6-р сард Монгол Улсад хийсэн БНТУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын явцад эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны өнөөгийн төвшин нь санаанд нь хүрэхгүй байгаад санал нэгдэж, идэвхтэй биш байгаа энэ харилцааг эрчимжүүлэхэд бололцоотой бүхнийг хийх шаардлагатайг онцлон тэмдэглэж, үр ашигтай саналууд харилцан хэлэлцэгдэж байгаа нь хоёр улсын найрсаг дотно харилцаа, хамтын ажиллагааг цаашид улам өргөжүүлэн гүнзгийрүүлж, илүү бодитой таатай нөхцөл бололцоог бий болгохын чухлыг харуулж байна.

2006 онд Туркийн Үндэсний Их Хурлын дарга Салык Якут тэргүүтэй төлөөлөгчид Монголд албан ёсоор айлчилж, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн баяр ёслолын арга хэмжээнд оролцов.

2006 онд Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд БНТУ-д албан ёсны айлчлал хийсэн нь хоёр талын уламжлалт найрсаг харилцаанд шинэ хуудас нээж, өндөр дээд хэмжээний айлчлал, яриа хэлэлцээний давтамжыг бататгаж, харилцаанд шинэ түлхэц болсон юм. Энэ нь Монгол Улсаас Ерөнхий сайдын төвшинд анх удаа Туркэд айлчилсан, Их Монгол Улсын 800 жилийн ойг түүх, соёлын уламжлалт харилцаатай Турк улсад сурталчлан таниулсан онцлог үйл явдал болов.

Түүнчлэн Монголын барилга орон сууцны салбарт Туркийн хөрөнгө оруулагчдыг татан оруулж, Туркийн барилгын тоннелийн системийг Монголд нэвтрүүлэх, мал аж ахуйн болон сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хамтран ажиллах уул уурхай, геологи, газрын тосны хайгуул, судалгааны ажлыг хийх, Станбул-Улаанбаатар хотын хооронд шууд нислэг үйлдэх зэрэг асуудлаар санал солилцож, Туркт бакалавраас гадна магистр, докторын сургалтанд монгол оюутнуудыг хамруулах мөн Туркийн Засгийн газрын тэтгэлгээр суралцах монгол оюутнуудын тоог нэмэгдүүлэхэд анхаарах болов. Түүнчлэн байгаль орчин, эрүүл мэндийн салбар болон хил хамгаалах байгууллагын харилцааг өргөжүүлэн ажиллахаар тохиролцов.

2004 оны эцсийн байдлаар Туркийн хөрөнгө оруулалттай 19 компани Монголд үйл ажиллагаагаа явуулж байгаагийн 12 нь худалдааны чиглэлээр ажиллаж байв.

Мөн 2005 онд хоёр орны худалдааны нийт эргэлт урьдчилсан байдлаар 1.844.8 мянган ам.долларт хүрч, Туркт гаргаж буй Монголын экспортын дийлэнх хувийг өлөн гэдэс, давсаг, гүзээ эзэлдэг ба импортоор Туркээс чихэр, саван, тоног төхөөрөмж, нийтийн тээврийн моторт хэрэгсэл авсан байна.

Мөн 2006 онд Турк улстай байгаль орчны салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулжээ.

Монгол Улсын Засгийн газар сүүлийн 5 жилд дундажаар 200 орчим сая долларын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийг жил бүр хүлээн авч байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 20 шахам хувьтай тэнцэж, манай орны нэг хүн амд жилд 90 орчим ам.доллар ноогдож байгаа нь дэлхийд дээгүүр үзүүлэлт юм.

Үүний нэгээхэн хэсэг нь БНТУ-аас Монгол Улсад үзүүлж ирсэн төрөл бүрийн тусламж, дэмжлэгүүд юм. Эдгээрийг дотор нь:

1. Боловсролын салбар
2. Хүмүүнлэгийн тусламж
3. Аялал жуулчлал
4. Батлан хамгаалах салбар гэж ангилан үзэж болох юм.

Монгол, Туркийн харилцаа, хамтын ажиллагаа олон салбарт идэвхтэй өрнөж, томоохон айлчлал арга хэмжээнүүд хэрэгжиж эхэлж байна.

**Боловсролын салбарт:** Боловсролын салбарыг ерөнхийд нь дунд болон, мэргэжлийн сургууль, шашны сургалт гэсэн 2 хэсэгт хувааж болох ажээ.

Монголын мусульман нийгэмлэгийн төлөөлөгчид 1991 онд эхлэн Турк улсад айлчилж тус улсын Шашны хэрэг эрхлэх Яам, Соёлын Яамны сайд нар болон бусад хүмүүстэй уулзаж харилцаа тогтоож

байжээ. Тус нийгэмлэгийн шугамаар Туркт 1993 оны байдлаар шашны болон бусад сургуульд 150 орчим хүүхэд төрөл бүрийн мэргэжлээр сурч эхэлжээ.

1995 оны байдлаар Туркийн их, дээд сургуульд Монголын 89 оюутан шашны шугамаар суралцаж байв. Мөн Монгол Улсын томоохон хот, аймгууд болох Улаанбаатар, Дархан, Баян-Өлгий зэрэг газруудад Турк лицей сургуулиуд нээж олон тооны сурагчид суралцаж байна. 2001 оноос эхлэн Туркийн ТИКА байгууллагын дэмжлэгтэйгээр МУИС-д Түрэг-Судлаач мэргэжилтнүүд бэлдэж эхэлсэн билээ. Мөн Монголын цэргийн албан хаагчдыг БНТУ-ын цэргийн сургууль, дамжаанд суралцуулж байна. 2004 оноос эхлэн жил бүрийн 4 дүгээр сарын 23-нд шилдэг хүүхдүүдийг шалгаруулж ТИКА байгууллагын зардлаар БНТУ-ын хүүхдийн фестивалд оролцуулдаг болжээ.

2005 оны 2 сарын 18-нд Монгол Улсын Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын хүсэлтээр 2000 сурагчдад бичиг хэргийн хэрэгсэл болон цүнх бэлэглэжээ.

**Хүмүүнлэгийн тусламж:** 1992 оны 6-р сард Туркийн тал хүмүүнлэгийн тусламж болгон 26 тонн хүнсний барааг 2 онгоцоор Улаанбаатарт хүргэж ирсэн.

Монголын малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд санхүү, техникийн тусламж үзүүлэв.

2006 оны сүүлээр Цагдаагийн Ерөнхий Газарт богино долгионы холбооны тоног төхөөрөмж хүлээн авсны сацуу Туркийн Хар тамхи мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Академитай хамтран хил хамгаалах болон цагдаагийн байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулав.

2007 оны эхээр ТИКА-олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар Цусны төв шинээр байгуулав.

**Аялал жуулчлалын салбарт:** 2006 онд Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын үеэр Монгол, Туркийн Засгийн газар хооронд ТИКА-гийн шугамаар Орхоны хөндий дэх эртний Түрэгийн хөшөө дурсгалыг түшиглэн музей байгуулах тухай протокол байгуулсан ба Хархориноос уг газарт хүрэх 50 гаруй км урт хатуу хучилттай авто замыг Өвөрхангай аймагт тавихаар болжээ.

Монголын Иргэний агаарын МИАТ компани, Туркийн Агаарын тээврийн компани хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулагдаж, Улаанбаатар-Станбулын хооронд шууд нислэг 1997 онд хийж эхэлсэн хэдий ч зорчигч эргэлт бага, эдийн засгийн ашиггүй гэсэн шалтгаанаар 1998 оны 12 сард зогсоосон байна.

2006 онд манай улс Турк улстай Байгаль орчны салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсан нь цаашдаа экологийн аялал жуулчлалын салбарт томоохон хөрөнгө оруулалт болох юм.

Мөн онд Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболдын Турк улсад хийсэн айлчлалын үеэр хоёр орны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, олон жил яригдаж ирсэн Туркийн Экзим банкны 20 сая ам.долларын зээлийг хөнгөлттэй нөхцлөөр авах сонирхолтой байгаагаа манай тал илэрхийлснийг Туркийн тал анхааралдаа авч нааштай шийдвэрлэхээ илэрхийлэв. Туркийн Экзим банкнаас Монгол Улсад олгохоор яригдаж буй зээлийн баталгааны асуудлыг хоёр тал Улаанбаатар хотноо таван одтой зочид буудал барихад зориулна гэдэгт санал нэгтэй байгаа бөгөөд үүнийг хамтран ажил хэрэг болговол энэ нь хоёр орны худалдаа, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд том түлхэц болох юм. Туркийн талаас олгох гэж буй энэхүү анхны зээлийг хэрэгжүүлбэл эдийн засаг, худалдааны харилцаа өргөжин дараа дараагийн хамтарсан төсөл хэрэгжих өргөн боломж нээгдэнэ гэж үзэж байна.

**Батлан хамгаалах салбарт:** Монголын малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд санхүү, техникийн тусламж, батлан хамгаалах салбарт цэргийн боловсон хүчин бэлтгэхэд тусламж дэмжлэг үзүүлэх болон Монгол орныг Дундад Азийн бүгд найрамдах бусад улсын төвшинд авч үзэж тусламж, дэмжлэг үзүүлэх болно гэж тэмдэглэсээр байгаа билээ.

Монгол Улс НАТО-тай харилцахад Турк улс туслахаа амлаж Ази тивд итгэлцлэлийг бэхжүүлэх, хамтран ажиллах таатай нөхцөл бий болгоход хамтран ажиллаж байна.

2006 онд Монгол Улсын Зэвсэгт Хүчний Жанжин Штабын дарга, дэд дарга тэргүүтэй 2 удаагийн төлөөлөгчид Туркт айлчилж, Туркээс цэргийн тоног төхөөрөмжийн тусламж үзүүлэх, терроризм болон энхийг сахиулах хүчний хүрээнд Монголын сонсогч нарыг сургалтанд хамруулах, НАТО-тай харилцаагаа өргөжүүлэхэд БНТУ-аас дэмжлэг авах зэргээр хамтран ажиллахаар тохиролцов.

Мөн Монгол Улсын ЦЕГ-т богино долгионы холбооны тоног төхөөрөмж хүлээн авсны сацуу Туркийн Хар тамхи мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх акедемитай хамтран хил хамгаалах болон цагдаагийн байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулав

Эдгээрээс гадна Монгол, Туркийн харилцааг орон нутгийн байгууллагын хүрээнд өргөжүүлэхэд анхаарснаар Анкара хотын

шугамаар Улаанбаатар хотноо 300 мянган ам.долларын төсөл хэрэгжүүлэхээр яриа хэлэлцээ явуулсан бөгөөд Их Монгол улсын 800 жилийн ойг тохиолдуулан Анкара хотноо 6 дугаар сард Чингис хааны нэрэмжит парк нээж улмаар Ерөнхий сайдын айлчлалын үеэр уг паркт Чингис хааны дурсгалын хөшөөг босгов. “Чингис хаан, түүний өв” үзэсгэлэнг 12 дугаар сард Туркийн Станбул хотноо нээж, соёл урлагийн олон арга хэмжээг хослуулан Туркийн ард түмэнд танилцуулсан нь манай орны эрт ба эдүгээг сурталчлах дорвитой арга хэмжээ болсон юм. Туркийн Боловсролын Яамтай байгуулсан гэрээний дагуу Увс аймгаас 10 оюутныг Турк улсад дээд сургуульд сургаж байна.

Ийнхүү даяаршлын өнөө үед дэлхийн улс орнуудын улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн амьдрал бүхэлдээ бие биеэс хамааралтай хөгжин тэлж байгаагийн нэг илрэл Монгол Улс Турк Улстай харилцаа, хамтын ажиллагаагаа идэвхжүүлэн хөгжүүлэхийн төлөө авч явуулж байгаа удаа дараагийн арга хэмжээ, гэрээ хэлэлцээр зээл тусламжаас тодорхой харагдаж байна.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Монгол улсын гадаад бодлогын хөх ном. УБ. 2006
2. М.Хурметхан. “Монгол улс Исламын шашинт орнуудын харилцаа”, УБ, 2004
3. Avrasya bulteni /Tika агентлагаас эрхлэн гаргадаг/ сэтгүүл
4. <https://www.CIA.Gov>.
5. “Mogolistan ulke raporu” ном
6. “Гадаад харилцаа” сэтгүүл 2001, 2004 он
7. [www.Tika.gov.tr](http://www.Tika.gov.tr)